



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2023. 03.15 № 609

танай _____-ны № _____-т

ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ
ИНСТИТУТ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
С.ОЧИР-ЭРДЭНЭ ТАНАА

Хот төлөвлөлт, судалгааны институт
ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт ¹³ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002031994

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/66/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Эвиденсе аудит ХХК

Захирал, ахлах аудитор: С.Бадамгарав

Утас: 99057121

Цахим хаяг: info@evidenceaudit.mn

Аудитор: Д.Шүрэнцэцэг

Утас: 95047121

Цахим хаяг: shurentsetseg.evidence@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	8
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2023. 03. 15 № 610

танай _____-ны № _____-т

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ..

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	538,133,859.53	771,975,598.27
1.1.02	Дансны авлага	868,646,324.98	643,859,653.98
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	27,197,277.47	15,781,049.91
1.1.04	Бусад авлага	702,893.25	436,182.58
1.1.06	Бараа материал	36,810,536.51	55,593,164.07
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	824,998.39
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,471,490,891.74	1,488,470,647.20
1.2.01	Үндсэн хөрөнгө	244,411,601.32	257,284,298.54
1.2.02	Биет бус хөрөнгө	3,139,200.00	2,208,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	247,550,801.32	259,492,298.54
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,719,041,693.06	1,747,962,945.74
2.1.1.01	Дансны өглөг	219,631,750.00	313,496,400.00
2.1.1.03	Татварын өр	20,822,977.11	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	25,971.00	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	240,480,698.11	313,496,400.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	240,480,698.11	313,496,400.00
2.3.01	Өмч: - төрийн	161,153,013.31	161,153,013.31
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,317,407,981.64	1,273,313,532.43
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	268,078,952.61	129,432,452.80
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,049,329,029.03	1,143,881,079.63
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,478,560,994.95	1,434,466,545.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,719,041,693.06	1,747,962,945.74

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,018,583,060.50	2,708,423,406.21
02	Борлуулалтын өртөг	1,661,886,921.57	1,720,964,345.29
03	Нийт ашиг(алдагдал)	1,356,696,138.93	987,459,060.92
08	Бусад орлого	113,863.64	-
08.1	Орлогын дүн	113,863.64	-
09	Борлуулалт, маркетингийн зардал	404,410,950.34	140,236,456.57
10	Ерөнхий ба удирдлагын зардал	654,371,690.95	679,698,566.37
12	Бусад зардал	18,716,300.00	-
12.1	Зардлын дүн	1,077,498,941.29	819,935,022.94
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(428,694.67)	2,038,582.13
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(18,149,169.92)
17.1	Олз, гарзын дүн	(428,694.67)	(16,110,587.79)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	278,882,366.61	151,413,450.19
19	Орлогын татварын зардал	10,803,414.00	21,980,997.39
20	Татварын дараах ашиг (алдагдал)	268,078,952.61	129,432,452.80
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	268,078,952.61	129,432,452.80

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,070,579,269.15	1,231,732,282.46
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(21,250,240.12)	(21,250,240.12)
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	268,078,952.61	268,078,952.61
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	161,153,013.31	1,317,407,981.64	1,478,560,994.95
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(173,526,902.01)	(173,526,902.01)
11	Залруулсан үлдэгдэл	161,153,013.31	1,143,881,079.63	1,305,034,092.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	129,432,452.80	129,432,452.80
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	161,153,013.31	1,273,313,532.43	1,434,466,545.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,378,995,846.58	3,348,084,379.84
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,582,224,462.58	2,363,997,946.84
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	18,284,888.00	9,760,052.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	615,267,800.00	615,267,800.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	163,218,696.00	359,058,581.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,185,091,291.37	2,874,273,193.23
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,022,904,372.56	925,020,249.77
37258	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	340,707,292.22	274,974,145.21
37623	Бараа материал худалдан авахад төлсөн	58,895,280.00	88,784,737.00
37988	Ашиглалтын зардалд төлсөн	63,855,132.00	46,404,436.00
38354	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,800,000.00	31,415,000.00
39084	Татварын байгууллагад төлсөн	340,841,611.91	348,463,820.74
39449	Даатгалын төлбөрт төлсөн	-	1,837,110.00
39815	Бусад мөнгөн зарлага	1,348,087,602.68	1,157,373,694.51
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	193,904,555.21	473,811,186.61
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	26,219,500.00	121,372,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	26,219,500.00	121,372,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(26,219,500.00)	(121,372,500.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	10,144,972.15
38047	Бусад		10,144,972.15
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,487,294.67	128,741,920.02
38048	Төлсөн ногдол ашиг	32,058,600.00	120,635,530.00

38413	Бусад	428,694.67	8,106,390.02
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,487,294.67)	(118,596,947.87)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	135,197,760.54	233,841,738.74
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	402,936,098.99	538,133,859.53
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	538,133,859.53	771,975,598.27

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1.1	Борлуулалтын орлого	2,459,362,564	2,482,902,300	2,149,089,043	-333,813,257	-13
1.2	Нийслэлийн төсвөөс	559,334,360	559,327,270	559,334,364	7,094	0
1	Нийт орлогын дүн	3,018,696,924	3,042,229,570	2,708,423,406	-333,806,164	-11
2.1	ББӨ	809,074,594	327,952,345	752,319,315	424,366,970	129
2.2	Цалин, нэмэгдэл	1,127,592,395	1,395,499,140	987,236,871	-408,262,269	-29
2.3	Хоол,унаа	122,080,000	204,820,000	111,260,000	-93,560,000	-46
2.4	НДШ	165,952,016	216,043,084	148,395,561	-67,647,523	-31
2.5	Түрээс, ашиглалт	63,418,768	76,200,000	47,058,982	-29,141,019	-38
2.6	Албан томилолтын зардал	780,000	49,868,000	40,997,484	-8,870,516	-18
2.7	Элэгдлийн зардал	71,507,933	101,891,695	91,281,833	-10,609,862	-10
2.8	Түүхий эд материалын зардал	93,239,677	80,314,860	75,575,423	-4,739,437	-6
2.9	Зар сурталчилгааны зардал	38,479,220	4,625,000	1,340,909	-3,284,091	-71
2.1	Сургалтын зардал	13,738,728	86,360,000	16,945,099	-69,414,901	-80
2.11	Эрдэм шинжилгээ	27,217,826	75,573,000	66,360,861	-9,212,139	-12
2.12	Шуудан холбооны зардал	13,043,423	17,802,000	8,879,887	-8,922,113	-50
2.13	Шатахууны зардал	14,913,636	35,560,000	24,009,092	-11,550,908	-32
2.14	Засварын зардал	19,203,363	51,000,000	45,811,140	-5,188,861	-10
2.15	УЗ-н зардал	23,310,000	29,602,000	28,299,600	-1,302,400	-4
2.16	Банкны шимтгэл	905,140			0	
2.17	Бусад зардал	22,064,770			0	
2.18	Валютын ханшийн бодит бус алдагдал	428,690			0	
2	Үйл ажиллагааны зардал	2,626,950,179	2,753,111,124	2,445,772,055	-307,339,069	-11
3	Үйл ажиллагааны бус зардал	112,864,376	132,090,000	111,237,901	-20,852,099	-16
4	Нийт зардал	2,739,814,555	2,885,201,124	2,557,009,956	-328,191,168	-11
5	Татвар төлөхийн өмнөх ашиг	278,882,371	157,028,446	151,413,450	-5,614,996	-4
6	Татварын зардал	10,803,414	15,702,845	21,980,997	6,278,153	40
7	Цэвэр ашиг	268,078,957	141,325,602	129,432,453	-11,893,149	-8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг компанийн дүрэмд дараах байдлаар тодорхойлжээ.

1. Хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, Үүнд:
 - 1.1 Газар нутаг хүн амын судалгаа
 - 1.2 Эдийн засаг, хөрөнгө оруулалтын судалгаа
 - 1.3 Нийгэм, соёлын судалгаа
 - 1.4 Зам тээвэр, инженерийн дэд бүтцийн судалгаа
 - 1.5 Байгаль орчин, аюулгүй байдлын судалгаа
 - 1.6 Газар ашиглалт, барилгажилтын судалгаа
 - 1.7 Шаардлагатай бусад судалгаа
2. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, Үүнд:
 - 2.1 Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл
 - 2.2 Бүсийн хөгжлийн төсөл
 - 2.3 Чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө
 - 2.4 Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
 - 2.5 Хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
 - 2.6 Шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө
 - 2.7 Барилга байгууламжийн зураг төсөл
 - 2.8 Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
 - 2.9 Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл

Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-ын зорилго нь түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.

Тус байгууллага нь 2022 онд “борлуулалтын орлогыг өмнөх оны зорилтоос бууруулахгүй байх, цэвэр ашгийн түвшнийг өмнөх оны зорилтоос бууруулахгүй байх, хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэх 3 зорилт дэвшүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ыг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2010 оны 50 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн зураг төслийн хүрээлэн ОНӨААТҮГ нэртэй байгуулсан ба 2020 оноос Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 116 дугаар тогтоолоор Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нэртэйгээр шинэчилсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь тус байгууллагын даргын 2018 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн А/20 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,921.3 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	538,133.9	771,975.6	233,841.7
Авлага	896,546.5	660,076.9	(236,469.6)
Урьдчилгаа	-	825.0	825.0
Бараа материал	36,810.5	55,593.2	18,782.6
Үндсэн хөрөнгө	247,550.8	259,492.3	11,941.5
Нийт хөрөнгө	1,719,041.7	1,747,962.9	28,921.3
Өр төлбөр	240,480.7	313,496.4	73,015.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,478,561.0	1,434,466.5	(44,094.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,719,041.7	1,747,962.9	28,921.3

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банк дахь харилцах дансанд байгаа 771,975.6 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 1,857.9 мянган төгрөг, НӨАТ-ын авлага 10,1535.2 мянган төгрөг, НДШ-ийн авлага 3,769.9 мянган төгрөг байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд үүссэн тендерийн баталгаа, гүйцэтгэлийн баталгааны авлага 91,697.1 мянган төгрөг, зураг төсөв боловсруулах ажлын үлдэгдэл авлага 25,026.0 мянган төгрөг, зохиогчийн хяналтын авлага 36,747.8 мянган төгрөгөөр буурсан нь авлагын бууралтад голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 394,638.7 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 265,438.1 мянган төгрөгийн барьцааны авлагыг барагдуулах талаар Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн замын хөгжлийн газар, Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт албан бичиг, холбогдох тооцоо нийлсэн актын хамт хүргүүлж ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,593.2 мянган төгрөг болж 18,782.6 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын худалдан авалт шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант хугацаанд шинээр 12,434.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 21,533.9 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, 20,831.7 мянган төгрөгийн хэвлэх, хувилах төхөөрөмж, 5,460.0 мянган төгрөгийн цахилгаан тоног төхөөрөмж, 61,112.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдан авсан, Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2022 оны 5 дугаар сарын 09-ны өдрийн А/166 дугаар тушаалаар 73,492.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/606 дугаар тушаалаар 49,950.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг данснаас хассан ба тайлант хугацааны элэгдлийн зардлыг тооцоолж бүртгэсэн байна.

Богино хугацаат ер төлбөр дансны үлдэгдэл 313,496.4 мянган төгрөг болж 73,015.7 мянган төгрөгөөр өссөн нь гэрээгээр ажил гүйцэтгэгчид өгөх өглөг өссөн нь шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын дарга байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн засаг даргын 2022 оны А/488 дугаар тушаалаар 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 3,042,229.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,885,201.1 мянган төгрөгөөр, 141,325.6 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 330,517.5 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,708,423.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,557,010.0 мянган төгрөгийн зардал гарган, 151,413.5 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,708,423.4 мянган төгрөг болж төлөвлөснөөс 333,813.3 мянган төгрөг буюу 11.0 хувиар тасарсан нь аж ахуй нэгж байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого багассан нь шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 2,557,010.0 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 319,486.9 мянган төгрөг буюу 11,0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь цалин, нэмэгдэл хөлс, хоол унааны зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, түрээс болон ашиглалтын зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 129,432.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 11,893.1 мянган төгрөгөөр дутуу байгаа нь тайлант үеийн үйл ажиллагааны орлого буурсан нь нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эвиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор Д. Шүрэнцэцэг, туслах аудитор Э.Билгүүн нар гүйцэтгэж, хяналтыг захирал, ахлах аудитор С.Бадамгарав, НТАГ-ын санхүү-нийцлийн хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа Эвиденсе аудит ХХК-д 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1/83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүү байдлын тайланг, суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны цэвэр хөрөнгийн 1,478,560.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,785.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласнаар цалин хөлс, хоол унааны зардал, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, албан томилолтын зардал, түрээс болон ашиглалттай холбоотой тогтмол зардал, шуудан холбооны зардал, сургалтын зардал, эрдэм шинжилгээний зардал зэрэг зардлаас нийт 319,486.9 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 4,817,258.8 мянган төгрөгийн 202 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 267,651.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг, 51,327.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг 15.0 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	267,651.8	1	39,834.2	15.0
Зөвлөмж	1	51,327.0	-	-	-
Нийт дүн	2	318,978.8	1	39,834.2	15.0

Хугацаа хэтэрсэн 267,651.8 мянган төгрөгийн барьцааны авлагыг барагдуулах талаар Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн замын хөгжлийн газар, Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт албан бичиг, холбогдох тооцоо нийлсэн актын хамт хүргүүлж ажилласны үр дүнд 39,834.2 мянган төгрөгийн барьцааны авлага төлөгдсөн ба үлдэгдэл авлагыг 2023 оноос чөлөөлж өгөх тухай албан хариунууд ирсэн байна. Иймд аудитын илрүүлэлтэд тусгаагүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дээрх барьцааны авлагын албан хариуны хэрэгжилтийг нөхөн үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЭВИДЕНСЕ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



С.БАДАМГАРАВ

Д.ШҮРЭНЦЭЦЭГ